



**ХӨВСГӨЛ АЙМГИЙН
ЦАГААН-УУЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 03 сарын 22 өдөр

Дугаар А/73

Цагаан-Уул сум

Орон тооны бус байнгын зөвлөлийг
татан буулгах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, "Тушаал хүчингүй болгох тухай" Монгол Улсын Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2024 оны 02 дугаар сарын 07-ны өдрийн А/20 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1. Хөвсгөл аймгийн Засаг даргын 2024 оны 02 дугаар сарын 21-ний өдрийн 1/318 дугаар албан бичгээр ирүүлсэн чиглэлийн дагуу даатгуулагчийн малчнаар ажиллаж нийгмийн даатгалын шимтгэл төлсөн хугацааг тодорхойлох Засаг даргын дэргэдэх орон тооны бус байнгын зөвлөлийг татан буулгасугай.

2. Засаг даргын дэргэдэх орон тооны бус байнгын зөвлөлийн шийдвэр, хурлын тэмдэглэл, бусад холбогдох баримт материалыг аймгийн Нийгмийн даатгалын газарт хүргүүлэхийг Нийгмийн даатгалын байцаагч, зөвлөлийн нарийн бичгийн дарга (Ц.Оюунлхагва)-д үүрэг болгосугай.

3. "Засаг даргын дэргэдэх орон тооны бус байнгын зөвлөл байгуулах тухай" сумын Засаг даргын 2022 оны 10 дугаар сарын 12-ны өдрийн А/178 дугаар захирамжийг хүчингүй болгосугай.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Д.Түмэнбаяр)-т даалгасугай.

ДАРГА  С.ТОНЧИГНЯМ



Zahiramj /2024/